

BUILDING TRUST



СИКА МОНГОЛИА ХХК-ИЙН
“СОНСГОЛОН-БЕТОН ЗУУРМАГИЙН
НЭМЭЛТ БОДИС ИМПОРТЛОХ,
АШИГЛАХ, ХАДГАЛАХ АГУУЛАХ”
ТӨСЛИЙН БОМТ-2025”
**БИЕЛЭЛТИЙН
ТАЙЛАН**

Байршил: УБ хот, Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо

2025 он

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	2
1.1 ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
2 ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	7
2.1 ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ХУРААНГУЙ.....	BOOKMARK NOT DEFINED.
3 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	8
3.1 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ	88
3.2 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	8
3.3 ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	222
3.4 ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	23
3.5 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	24
3.6 ХОГ ХАЯГДАЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	366
3.7 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	45
3.8 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	51
3.9 Нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах хөтөлбөр	51
4 ДҮГНЭЛТ	51
5 ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ	55

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА


1.1 Төслийн товч танилцуулга

Төслийн нэр:	Бетоны нэмэлтийн агуулах
Төсөл хэрэгжүүлэгч:	“Сика Монголиа” ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9019071038
Регистрийн дугаар:	5641683
Хаяг:	Компанийн төв оффис нь УБ хот, СБД, 1-хороо, Ландмарк товер 502 тоотод байрладаг
Холбоо барих утас:	+976-9595-9433; 7013-1360

Сика Монголиа ХХК нь Швейцар улсын Sika® AG групп компанийн 76 дахь салбар охин компани болж 2012 онд үүсгэн байгуулагдсан. Бид үүсгэн байгуулагдсан цагаасаа өнөөг хүртэл Сика брэндийн бетоны нэмэлтийг Монгол орны эрс тэс уур амьсгалд зориулан бүтээгдэхүүний хөгжүүлэлтийг тогтмол хийж байгаа бөгөөд бүтээгдэхүүний нэр төрөл, сонголтыг нэмэгдүүлж, хэрэглэгчийн хүсэлт, шаардлагын дагуу байнгын сайжруулалт хийж ажилласаар байна.

Sika® бренд нь тусгай зориулалтын химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч бөгөөд барилгын салбарт бетоны нэмэлт, ус чийг тусгаарлах, дээвэр, шал, заадас, чигжээс болон холбоос, бүтээцийн хүчитгэгч болон авто машин үйлдвэрлэлийн салбарт барьцалдуулагч, чигжээс, ус чийг тусгаарлагч, хүчитгэгч, гадаргуу хамгаалах зориулалт бүхий нэмэлт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлдвэрлэлийн систем хөгжүүлэлтийн чиглэлээр дэлхийд тэргүүлэх үйлдвэрлэгч юм.

Sika® бренд нь анх 1910 онд үүсгэн байгуулсан бөгөөд 2024 оны жилийн эцсийн байдлаар дэлхийн 103 гаруй улсад өөрийн салбар компанитай, нийт 400 гаруй үйлдвэр, агуулах, туршилт судалгааны төвөөр дамжуулан бүтээгдэхүүн хөгжүүлэлт, үйлдвэрлэл, түгээлтийг хийж байгаа бөгөөд 33000 гаруй ажилтантай болоод байна.



Зураг 1. Sika® AG группийн бүс нутгийн салбарууд

Сика Монголиа ХХК нь хэрэглэгч, харилцагч нартаа чанартай, техникийн шаардлага хангасан бүтээгдэхүүн нийлүүлэх үүднээс бүх бүтээгдэхүүнээ тохирлын гэрчилгээжүүлж, баталгаажуулсан. Мөн 2021 оноос менежментийн тогтолцооны ISO 9001 - Чанарын Удирдлагын Тогтолцоо, ISO 45001 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны стандартыг нэвтрүүлсэн бөгөөд 2023 онд тус хоёр стандартын магадлан итгэмжлэлд дахин хамрагдаж, амжилттай сунгасан.

Төслийн байршил

Төслийн байршил: “Сика монголиа” ХХК-ийн “Бетон зуурмагийн нэмэлт бодис импортлох, ашиглах, хадгалах агуулах” төсөл нь Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутагт, Иргэн Ж. Энх-Отгоны 1.4 га талбайд үйл ажиллагаа явуулна.

Уг төслийн байршил нь ДЦС-4 -ийн баруун тал, цахилгаан станцийн үнс зайлуулах талбайн зүүн талд, Туул голын баруун эргээс хойд зүгт 1.5-3.1 км зайд, УБ хотын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс, тэжээгдлийн мужийн гадна, мөн Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалт, эрүүл ахуйн бүсийн гадна, Сонгинохайрхан дүүргийн үйлдвэрлэлийн бүсэд оршино.



Зураг. 1. Төслийн талбайн байршлын зураг

Химийн бодисын агуулах

Тус агуулахын байр нь 2023 онд ашиглалтад орсон, төмөр карказан бүтэцтэй, сендвичэн хийцтэй 624м2 талбай бүхий объект байна. Тус агуулахыг “Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүн агуулах” ерөнхий шаардлага MNS 6458:2014 болон Аж ахуй нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм MNS 5566 : 2020 стандартуудын шаардлагад нийцүүлэн галын хор, галын сарайн иж бүрдэл, утаа мэдрэгч, галын гар мэдээлэгч, шугаман утаа мэдрэгч, хяналтын камер, GSM дамжуулагч, галын булан, ослын гэрэлтүүлэг, галын аюулгүй байдлын самбар, тэмдэг, тэмдэглэгээг байршуулан, 24 цагийн камерийн нэгдсэн систем, гэрээт харуул хамгаалалттайгаар ашиглаж байна.

Дотороо 20м2 бүхий ажилчдын амралт, анхны тусламжийн өрөө болон камерийн хяналтын 2ш тусдаа өрөөтэй, шаардлагатай зүйлсээр тоноглож, тохижуулсан.

Тус бетоны нэмэлтийн түүхий эдийн агуулахад 2-3 нэр төрлийн хуурай түүхий эдийг бүтээгдэхүүний зориулалт, хэрэглээ, тоо хэмжээ, техникийн шаардлага, бүтээгдэхүүн худалдан

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Сика Монголиа” ХХК-ийн БЕТОН ЗУУРМАГИЙН НЭМЭЛТ БОДИС ИМПОРТЛОХ, АШИГЛАХ, ХАДГАЛАХ АГУУЛАХ төслийн 2025 оны БОМТ – БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

авалт нийлүүлэлт, цаг хугацаа, улирал гэх мэт олон хүчин зүйлийг үндэслэн импортлон оруулж ирж, нөөцлөн хадгалж байна.

Барилгын бусад бараа материалын ихэнх төрөл нь хадгалалтын хугацаа богино тул хэрэглэгчийн хүсэлт, захиалгын дагуу импортлон, нийлүүлдэг.



Зураг 1-10. Сонсголон-Түүхий эдийн агуулахын дотор тал

Сика Монголиа ХХК нь Сонсголон-Бетоны нэмэлтийн агуулах нь галын аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангаж Галын дүгнэлтийг Сонгинохайрхан дүүргийн Онцгой байдлын хэлтэсээс авсан. Галын дүгнэлтийг 12 сард сунгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Зураг 1-11. Сонсголон-Түүхий эдийн агуулахын гал унтраах шуурхай төлөвлөгөө болон галын дүгнэлт

2 ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

“Сика Монголиа” ХХК нь тус "Бетон зуурмагийн нэмэлт бодис импортлох ашиглах хадгалах агуулах" төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болох болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг нарийвчлан тогтоох зорилгоор Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг 2024 оны 5-р сард “Хас цас” ХХК-аар хийлгүүлсэн болно.

Хүснэгт 2-1. Төслийн голлох сөрөг нөлөөлөл

Эх үүсвэр	Хөрс	Агаар	Эдэлбэр газар
Химийн түүхий эдийн сав, боодлын хаягдал	Химийн бодисын хаягдал сав, боодлын хаягдал		
Агуулах орчны тоосжилт		Бодис тээвэрлэх явцад агаарт тоосжилт үүснэ.	
Ахуйн хог хаягдал үүсэх	Хог хаягдлын судалгаанаас үзвэл өдөрт 1.5 кг, 1 жилийн хугацаанд 370.5кг ахуйн хатуу хог хаягдал гарах болно.		
Төслөөс үзүүлэх дуу чимээ		Агуулахын дотоод агаар орчинд дуу чимээний тархалт үүснэ.	

Хүснэгт 2-2. Төслөөс газрын гадаргад нөлөөлөх байдал үнэлгээ

НӨЛӨӨЛӨЛ	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ			
	Бага	Дунд	Их	Онц Аюултай
Ахуйн хог хаягдлыг тогтоосон цэгээс өөр газарт хаяж, хөрс бохирдуулах	х			
Химийн бодисыг зөөж тээвэрлэх үед санамсаргүй асгарч хаягдах		х		
Тээвэрлэлтээс тоосжилт үүсэх	х			
Нийт нөлөөллийн агуулахаас хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөх нөлөөллийг “БАГА” гэж үзлээ.				

Тус Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутагт хэрэгжих Бетон зуурмагийн нэмэлт бодис импортлох ашиглах хадгалах агуулах төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга болон хэвлийд нөлөөлөх нөлөөлөл бага зэрэг сөрөг нөлөөлөлтэй байна.

Хүснэгт 2-3. Төслөөс агаарын чанарт нөлөөлөх байдал, үнэлгээ

НӨЛӨӨЛӨЛ	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ			
	Бага	Дунд	Их	Онц Аюултай
Химийн бодисыг хадгалах үед агуулахад химийн бодис уурших дотоод агаарын бохирдол үүсэх	х			
Ажилчдын эрүүл мэндэд нөлөөлөх		х		
Агуулахын дотоод орчиноос гадагш агаарын бохирдол алдагдах	х			
Химийн бодисыг зөөж тээвэрлэх болон агуулахаас ачих, буулгах тээврийн хэрэгслээс ялгарах утаа орчинд нөлөөлөх			х	
Нийт нөлөөллийн агаарын чанарт нөлөөлөх нөлөөллийг “БАГА” гэж үзлээ.				

Төсөл хэрэгжих талбайн ойр орчимд гадаргын ус байхгүй байна. Харин төсөл хэрэгжүүлэгч химийн бодисоо болгоомжгүй байдлаасаа болж асгавал хөрсөнд нэвчсэн бодис гүний усанд нөлөөлнө.

Хүснэгт 2-4. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчмийн үнэлгээ

№	Сөрөг нөлөөлөл	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ			
		Бага	Дунд	Их	Хүчтэй

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Сика Монголиа” ХХК-ийн БЕТОН ЗУУРМАГИЙН НЭМЭЛТ БОДИС ИМПОРТЛОХ, АШИГЛАХ, ХАДГАЛАХ АГУУЛАХ төслийн 2025 оны БОМТ – БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

1	Төслийн үйл ажиллагаагаар гадаргын усан сүлжээ өөрчлөгдөх	х			
2	Агуулахын үйл ажиллагааны улмаас газрын доорх усны нөөцөд нөлөө үзүүлэх		х		
3	Газар доорхи усны баланс алдагдах, химийн найрлага нь өөрчлөгдөж бохирдох		х		
4	Төслийн үйл ажиллагаанаас гарах ахуйн болон үйлдвэрийн хог хаягдал нь газрын доорх усны чанарт сөрөг нөлөө үзүүлэх		х		
Нийт нөлөөллийн усанд үзүүлэх сөрөг нөлөөлөл ДУНД зэргийн нөлөөлөл үзүүлэхийг харуулж байна.					

Төсөл хэрэгжих талбайд ахуйн болон агуулахын хог хаягдлыг зориулалтын дагуу хогын цэгт хаяхгүй ил задгай хаяснаас болж химийн бодис хөрсөнд нэвчих амьтад хортох элдэв өвчин тусах зэрэг сөрөг нөлөөллүүд бий болно.

Хүснэгт 2-5. Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчмийн үнэлгээ

№	Нөлөөлөл	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ			
		Бага	Дунд	Их	Хүчтэй
1	Агуулахын үйл ажиллагааны нөлөөнд үржил шимт хөрс бүхий талбай өртөх	х	-	-	-
2	Агуулахын үйл ажиллагааны үед ахуйн гаралтай хаягдал, химийн бүтээгдэхүүний хаягдлаар хөрсөн бүрхэвч бохирдох	-	х	-	-
3	Хөрсний шимт бодисын нөөц хомсдох, хөрсний гадаргын ургамал бүрхэц сийрэгжсэнээр хөрс эвдрэх үйл явц түргэсгэх	х	-	-	-
4	Хөрсний хими, физик, геохими, биохимийн хөдлөл зүйн горим өөрчлөгдөх	х	-	-	-
5	Хөрс хуурайшиж, бүтэц нь алдагдаж, элэгдэх, механик үйлчлэлээр талхлагдаж сийрэгжих, нимгэрэх	х	-	-	-
6	Хог ургамалд баригдах, доройтох, ахуйн хогоор бохирдох,	-	х	-	-
Нийт нөлөөллийн хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөлөл БАГА байгааг харуулж байна.					

Төслийн үйл ажиллагаанаас ургамлан бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл нь бодис тээвэрлэлт үед асгарах алдагдах эрсдэл бий болж болох бөгөөд үүнээс үүдэн ургамал талхлагдах, устах эрсдэл бий болох магадлалтай.

Хүснэгт 2-6. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчмийн үнэлгээ

№	Сөрөг нөлөөлөл	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ			
		Бага	Дунд	Их	Хүчтэй
1	Агуулахын үйл ажиллагааны нөлөөнд үржил шимт хөрс бүхий талбай өртөж ургамлан нөмрөгийн байгалийн унаган төрх алдагдах	х			
2	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний үед гарах тоосоор тодорхой талбайн ургамал дарагдах		х		
3	Ашиглалтад өртөх талбайн ургамлан нөмрөг бүхэлдээ устаж үгүй болно	х			
4	Тээврийн хэрэгслийн нөлөөгөөр ургамлан нөмрөг тоосонд дарагдах	х			
Нийт нөлөөллийн ургамалд үзүүлэх сөрөг нөлөөлөл БАГА байгааг харуулж байна.					

3 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

3.1 Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний зорилт

“Сика Монголиа” ХХК-ийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй эрсдэлийг илрүүлэх, тэдгээрийн үр дагаврыг тогтмол хянах, хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах үүрэгтэй.

2025 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нийт **54,206,933.0** төгрөг буюу тавин дөрвөн сая хоёр зуун зургаан мянга, есөн зуун гучин гурван төгрөгийг зарцуулсан байна. Тус зардалд үйл ажиллагааны зардлуудыг тооцон оруулж тооцоогүй болно.

БОМТ хэрэгжүүлэх арга хэмжээний дагуу хийж гүйцэтгэсэн ажлын зардлын зарцуулалтын хураангуйг хүснэгт 3-1-д харуулав.


Хүснэгт 3-1. БОМТ зардлын хураангуй

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Нийт гарсан зардал /төгрөг/
Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө	10,406,220.0
Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	1,200,000.0
Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	25,370,323.0
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	16,561,390.0
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	669,000.0
Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө	ҮАЗ
Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	ҮАЗ
БОМТ-ний ажлын нийт зардал	54,206,933.0 төгрөг

3.2 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт


Хүснэгт 3-2 сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, CO ₂ -ийн ялгаралыг бууруулах
Тус Сонсголон агуулахын төсөл дээр савлах, шилжүүлэн ачих зэрэг процесс хийгдэхгүй, мөн шатаах үйл ажиллагаа явуулдаггүй тул агаар орчинд сөрөг нөлөөгүй. Мөн Сика корпорацийн тогтвортой хөгжлийн бодлогын (Sika's Net Zero Strategy-2050) дагуу 2023-2028 онд баримтлах CO ₂ ийн ялгаралыг тогтмол бууруулах зорилт тавьж ажиллаж байна. Үүний хүрээнд 2032 он гэхэд нийт score-3 хүлэмжийн хийн ялгаруулалтыг 2022 оны суурь түвшинтэй харьцуулахад 30%, 2050 он гэхэд 90% хүртэлх хувиар бууруулах зорилт тавин ажиллаж байна.



Зураг 3-1. Sika's Net Zero Strategy-2050

Үүний хүрээнд Сика Монголиа ХХК нь үйл ажиллагаанд зарцуулж байгаа цахилгаан эрчим хүч, түлш шатахуун, ус, хог хаягдлын хэмжээг бүртгэн, улирал тутам Тогтвортой хөгжлийн тайлан мэдээ гаргаж, түүний ялгаруулж байгаа хүлэмжийн хийн тооцооллыг гарган ажилладаг. Цаашид сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг дотоодын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн нэмэгдүүлэх, өөрсдийн үйл ажиллагаанаас ялгаруулсан хүлэмжийн хийн хэмжээг дүйцүүлэх үүднээс монгол улсад хэрэгжиж байгаа сэргээгдэх эрчим хүчний төслүүдэд Carbon Credit механизмаар хөрөнгө оруулалт хийж, ногоон гэрчилгээ худалдан авахаар зорилт тавин ажиллаж байна.




Зураг 3-2. Цахилгаан эрчим хүчний хэрэглээ, мВт/ц

Сика Монголиа ХХК нь түлш шатахууны шууд хэрэглээнээс үүдэлтэй хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах, ажлын байрны агаар орчны чанарыг сайжруулах үүднээс цахилгаан сэрээт өргөгчийг түлхүү ашиглах бодлого барьж байгаа бөгөөд 2024 онд 3ш цахилгаан сэрээт өргөгчийг шинээр ашиглаж эхлээд байгаа бөгөөд компанийн хэмжээнд нийтдээ 7 сэрээт өргөгч ашиглаж байна.




Зураг 3-3. Сэрээт өргөгчийн зураг

Компанийн хэмжээнд машин техник, сэрээт өргөгчийн ашиглалт, шатахуун зарцуулалтын хэмжээг тогтмол хянаж шууд ба шууд бус эрчим хүчний хэрэглээнээс ялгарах CO₂-н хэмжээг тооцоолон улиралт тутам групп компанид тайлагнадаг.



Зураг 3-4. Компанийн түлш, бензин зарцуулалтын тоо мэдээ, 2025 оны 3-р улирлын байдлаар

Компанийн тогтвортой хөгжлийн тайлан мэдээний дагуу улирал тутам үйл ажиллагаанаас ялгаруулж байгаа хүлэмжийн хийн хэмжээг олон улсын стандартын дагуу тооцоолон тайлагнадаг.



Зураг 3-5. 2025 оны II улирлын хүлэмжийн хийн ялгаруулалтын тооцоолол

Сика Монголиа ХХК нь 2025 оноос борооны усыг цуглуулж авах 2 цэг гаргасан ба цуглуулсан борооны усыг ногоон байгууламжийн усалгаа, гадна зам талбайн тоосжилтыг дарах зорилгоор ашиглаж эхэлсэн. Энэ онд бид нийтдээ 9тн борооны ус цуглуулан, зам талбайн усалгаанд ашигласан байна. /Хавсралт 1. Борооны ус цуглуулах материалын төлбөр – 286,220 төгрөг/.



Зураг 3-6. Борооны цуглуулах цэг гаргасан, зам талбай усалж буй байдал

Сика Монголиа ХХК нь 2025 оны 06 дугаар сард Сонсголон агуулахын гадна болон дотор орчны агаараас 2 цэгээс дээж авч Хан-Уул дүүрэг дэх Цаг Уур, Орчны Шинжилгээний Газрын дэргэдэх Байгаль Орчин, Хэмжил Зүйн Төв Лабораторид шинжлүүлж, орчны хяналтыг тавьж ажилласан. Хэмжилтийн үр дүнг Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр хэсэг дэлгэрэнгүй оруулав.



Зураг 3-7. Дотор, гадна орчны агаарын хэмжилт хийж буй байдал

Дуу чимээний сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх

Сика Монголиа ХХК нь 2025 оны 06 дугаар сард Сонсголон агуулахын дотор орчинд шуугианы хэмжилтийг Хан-Уул дүүрэг дэх Цаг Уур, Орчны Шинжилгээний Газрын дэргэдэх Байгаль Орчин, Хэмжил Зүйн Төв Лабораториар хэмжүүлсэн. Хэмжилтийн үр дүнг Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр хэсэг дэлгэрэнгүй оруулав.

Компанийн зүгээс Сонсголон агуулахад ачаа бараа хүлээн авах, ачих, буулгах ажиллагаа гүйцэтгэж байгаа ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, шаардлагатай ХХХ, тусгай хамгаалах хэрэгслээр бүрэн хангасан ба хэрэглээ дээр хяналт тавьж ажилладаг. Ажлын байранд хувийн хамгаалах хэрэгсэл хэрэглэх аюулгүй ажиллагааны самбар, тэмдэг тэмдэглэгээ, зааварыг ажлын байранд байршуулсан байдаг.

Шаардлагатай ажлын байруудад нэг удаагийн чихний бөглөө болон сонсгол хамгаалах хэрэгслээр бүрэн хангасан байдаг.



Зураг 3-8. Сонсгол хамгаалах хэрэгсэл олгосон байдал

Хөрсөн орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх

Уг агуулах нь УБ хотын үйлдвэрийн бүс буюу техноген нөлөөлөлд өртсөн газарт байрлахын зэрэгцээ үйлдвэрийн талбай, зорчих зам нь хатуу хучилттай тул хөрсөн орчинд сөрөг нөлөөгүй.

Агуулахын үйл ажиллагааны явцад ялгарах ахуйн хог хаягдлыг ангилан ялгах зориулалтай хогийн савыг ажлын байруудад байршуулсан, ажилчдад хэрхэн ангилан ялгахыг дотоод сургалтаар заадаг. Агуулахын үйл ажиллагаанд байнгын ажиллагаатай биш тул бүтэн цагаар агуулах дээр ажилладаг ажилтан байхгүй. Тиймээс ахуйн хог хаягдал үүсдэггүй. Улирал тутам хог хаягдлын тайланг СХД-т хүргэж ажилласан /Хавсралт 2. 2025 оны 1-3 улирлын хог хаягдлын тайлан/.




Зураг 3-9. Ажлын байранд ангилдаг хогийн сав байрлуулсан байдал

Сика Монголиа ХХК нь 2025 оны 06 болон 10 дугаар сард нийт 2 удаа агуулахын хашааны 2 цэгээс хөрсний дээж авч хөрсний агрохимийн болон хүнд металлын шинжилгээг холбогдох лабораториудад өгч шинжлүүлсэн. Хэмжилтийн үр дүнг Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр хэсэг дэлгэрэнгүй оруулав.



Зураг 3-10. Агуулахын хашаанаас хөрсний дээж авч буй байдал

Химийн бодисын асгаралт үүсэх, хөрсний бохирдол үүсгэхээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангах үүднээс Нийслэлийн ОБЕГ-ийн Гамшгийн шуурхай удирдлагын хэлтэст хүсэлт өгч Химийн бодисын асгаралтаас урьдчилан сэргийлэх, ослын үед ажиллах төлөвлөгөө боловсруулах арга зүйн сургалт зөвлөгөө авч холбогдох төлөвлөгөөг боловсруулан дотооддоо дадлага сургуулилт хийж ажилласан.



Зураг 3-11. Нийслэлийн ОБЕГ-аас Химийн бодисын ослын төлөвлөгөө боловсруулах сургалт авч буй байдал



Зураг 3-12. Химийн бодисын асгаралтын үед ажиллах дадлага сургуулилт зохион байгуулсан байдал

Өргөн ашиглагддаг түүхий эд, бараа бүтээгдэхүүний Хор Аюулын Лавлах Мэдээлэл (MSDS) -ийн матрицыг нэгтгэн ажилчдад танилцуулан ажлын байранд байршуулсан.



Зураг 3-13. Химийн бодисын ХАЛМ матриц ажлын байранд байршуулсан байдал

Амьтан, ургамалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

Сика Монголиа ХХК нь “Хустайн цогцолборт газар” ТББ-тай хамтран тус тусгай хамгаалалттай газарт байгаа Тахийн сүрэг, буга, гөрөөс зэрэгт хужир мараа, эрдэсийн долооц тавьж өгөх биотехникийн арга хэмжээ болон орчны цэвэрлэгээ хийх ажлыг 2025.05.02-нд зохион байгууллаа. Тус байгалийн цогцолбор газарт 17 сүрэг азарга бүхий 300 орчим тахь болон буга гөрөөс, цагаан зээр, тарвага, чоно, аргаль хонь, тарвага зэрэг ан амьтан байдаг юм байна.

/Хавсралт 3. Хустайн Нурууны тусгай хамгаалалттай газрын ан амьтанд хужир мараа, эрдсийн долооц тавьж өгөх, олон нийтийн ажлын төсөв– 1,810,000 төгрөг/.



Зураг 3-14. Хустайн Нурууны тусгай хамгаалалттай газар ажилласан байдал

Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх

Ажилчдийн ундны усыг цэвэршүүлэн савласан зөөврийн цэвэр усаар хангаж байна.



Зураг 3-15. Цэвэршүүлсэн ундны ус, ус цэвэршүүлэгч ажлын байранд байршуулсан байдал

Сика Монголиа ХХК нь Сонсголон агуулахын байршил дээр “Хаягдал усны дүгнэлт”-ийг Туул Голын Сав Газрын захиргаанд хүсэлт өгч, ажилчдын ундны усны хэрэглээнд тургуулан гаргуулсан. Одоогоор тус агуулах дээр байнгын ажилтан ажиллахгүй байгаа тул хаягдал ус цуглуулах, соруулах үйл ажиллагаа хийгдээгүй болно. Цаашид байнгын ажилтан бүтэн цагаар ажиллах тохиолдолд зориулалтын соруулдаг бохирын худгийг төлөвлөсөн ба холбогдох хууль, журмын дагуу хаягдал ус зайлуулах зөвшөөрлийг дүүргээс авч, хаягдал усны дээжийг авч шинжлүүлж байхаар төлөвлөж байна.



Туул голын сав газар

ХАЯГДАЛ УСНЫ ДҮГНЭЛТ

2025 оны 09 -р сарын 04 -ны өдөр

Дугаар Е-2508-000015

Нэг. Ерөнхий мэдээлэл

1.1. Иргэн, аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар:

Оноосон нэр:	Сикамонголиа
Улсын бүртгэлийн дугаар:	
Регистрийн дугаар:	5641683
Захирал:	Лхагвасүрэн
Холбоо барих дугаар:	70131360

1.2. Төслийн нэр, байршил:

Төслийн нэр:	Сика Монголиа ХХК, Бетон зуурмагийн нэмэлт бодис импортлох ашиглах хадгалах агуулах” төсөл
Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалт:	
Байршил:	Улаанбаатар, Сонгинохайрхан, 20-р хороо


Зураг 3-16. Хаягдал усны дүгнэлт гаргуулсан байдал

Удирдлага зохион байгуулалтын талаар

Компани нь тус агуулахын байршилд Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээг хийлгэхээр гэрээт байгууллага сонгон шалгаруулж, ажлыг хийлгэж эхлээд байна /Хавсралт-4. Гамшгаас хамгаалах эрсдэлийн үнэлгээний гэрээт ажил- 5,300,000 төгрөг/.

Батлав. Захиалагч
“СИКА МОНГОЛИА” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ж.ЛХАГВАСҮРЭН

Батлав. Гүйцэтгэгч
“ОЧИРТ СЭРГЭЭН БОСГОЛТ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Г.ТӨМӨРСҮХ

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ
ХИЙХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2025 оны 10 р сарын 09-ны өдөр №. ГЗҮ- Улаанбаатар хот

Нэг талаас: “Очирт сэргээн босголт” ХХК /РД:5996856/, түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал Г.Төмөрсүх (Цаашид “Гүйцэтгэгч” тал гэх), нөгөө талаас “Сика Монголиа” ХХК /РД: 5641683/ түүнийг төлөөлж Гүйцэтгэх Захирал Ж.Лхагвасүрэн (Цаашид “Захиалагч” тал гэх) нар дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч тал нь “Сика Монголиа” ХХК-ийн УБ хот, СХД, 20-р хороонд байрлах Бетоны нэмэлтийн түүхий адийн агуулахын гамшгийн эрсдэлийн үнэлгээг /цаашид “Гэрээт ажил” гэх/ гэрээнд заасан хугацаанд хийж гүйцэтгэхтэй холбоотойгоор талуудын хооронд үүсэх эрх, үүрэг, хариуцлагын харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор гэрээний бүхий л хугацаанд талууд харилцан ойлголцож, хамтран ажиллана.
- 1.3 Гамшгийн эрсдэлийн үнэлгээг дараах төрлүүдээр хийж гүйцэтгэнэ.
 - 1.3.1 Объектын гал түймрийн эрсдэл
 - 1.3.2 Газар хөдлөлийн эрсдэл
 - 1.3.3 Үерийн эрсдэл
 - 1.3.4 Химийн ослын эрсдэл

Зураг 3-17. Эрсдэлийн үнэлгээ хийх ажлын батлагдсан гэрээ

2025 оны үйл ажиллагааны зардалын хүрээнд ажилчдад шаардлагатай хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, галын аюулгүй байдал, химийн бодистой харьцан ажилладаг ажилчдын сургалт, шаардлагатай хувийн хамгаалах хэрэгслээр бүрэн хангаж ажиллаж байна.

Сика Монголиа ХХХ нь 2025 онд нийтдээ шинээр 6 ажилтан ажилд авсан бөгөөд бүх шинэ ажилчдыг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулсан /Хавсралт-5. Эрүүл мэндийн урьдчилсан үзлэгийн зардал- 1,200,000 төгрөг/. Мөн байгууллагын хувийн эрүүл мэндийн даатгалын хүрээнд бүх ажилчид эрүүл мэндийн багц үзлэг, шинжилгээнд хамруулан ажилладаг.

Мөн бүх ажилчдад шаардлагатай ажлын хувцас, тусгай хамгаалах хэрэгслийг 2025 оны БОХАБЭА-ийн төсөвт суулгасны дагуу ажлын байрны онцлог тус бүрт тохируулан олгож байна /Хавсралт-6. Нийт ажилчдад олгосон ажлын хувцас, тусгай хамгаалах хэрэгслийн нэгдсэн жагсаалт, 2025 оны эхний 10 сарын байдлаар/.

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Сика Монголиа” ХХК-ийн БЕТОН ЗУУРМАГИЙН НЭМЭЛТ БОДИС ИМПОРТЛОХ, АШИГЛАХ, ХАДГАЛАХ АГУУЛАХ төслийн 2025 оны БОМТ – БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

№	Нэр төрөл	Тоо хэмжээ, ш
1	Ажлын куртик, цамц	67
2	Ажлын өмд	45
3	Ажлын гутал	23
4	Нүдний шил	57
5	Ажлын бээлий	2670
6	3М Маск	2375
7	Бусад хамгаалах хэрэгсэл	17

Сика Монголиа ХХК нь групп компанийн Байгаль Орчин, Хөдөлмөрийн Аюулгүй Байдлын Бодлого, Амь Нас Хамгаалах 10 Дүрэм, Сика-ийн Хамгийн Бага Шаардлага болон бусад дүрэм журам, МУ-ын ХАБЭА тухай хууль тогтоомж, дүрэм журмын дагуу аюулгүй ажиллагааны заавар, журмыг боловсруулан компанийн удирдлагаар батлуулан ажлын байр тус бүрээр нь танилцуулдаг. Мөн тухайн ажилтай холбоотой өдөр тутмын зааварчилгаа, зөвшөөрлийн системийг мөрдөн ажилладаг.

[illegible]

Зураг 3-18. Сика-ийн БОХАБЭА бодлого, үндсэн дүрэм журмууд

БАТЛАВ.
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ж.ЛХАГВАСҮРЭН

BUILDING TRUST



**АЛБАН ТАСАЛГАА (ОФФИС)-Д АЖИЛЛАХ
АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА**

АЖИЛ ЭХЛЭХИЙН ӨМНӨХ:

- Ажилдаа ирэхдээ хангалттай үнэ автаагүй байх;
- Гадуур хувцсыг зориулалтын шү
- Үйлдвэр, агуулах, лаборатори ажиллагааны зааварчилгаатай т дараа тухайн хэсгийн холбогдох шил, каск заавал хэрэглэх, бар түршилт хийх зэрэг тохиолдол хамгаалах хэрэгсэл нэмэлтээр х тоног төхөөрөмж ажиллуулахыг
- Химийн бодисын асгаралт, он хориглоно, усны гутлыг зөвхөн л
- Гэрээт байгууллагын ажилчдад ажиллах, тэдгээрийн аюулгүй аж
- Ажлын ширээ, сандал, хувцасны цахилгаан хэрэгслүүдийн хэвийн ачаалал үүсгэсэн, залгуурыг ду аюулгүй байдлыг хангана;
- Дээрх шалгалтуудыг хийх үед арилгасны дараа ажил үүргээ эх

БАТЛАВ.
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ж.ЛХАГВАСҮРЭН

BUILDING TRUST




**БЕТОНЫ НЭМЭЛТИЙН ҮЙЛДВЭР, АГУУЛАХАД АЖИЛЛАХ
АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА**

АЖИЛ ЭХЛЭХИЙН ӨМНӨХ:

- Ажилдаа ирэхдээ хангалттай унтаж амарсан, архи согтууруулах ундаа болон мансууруулах бодисын нөлөөнд автаагүй байх. Хангалттай унтаж амраагүй, ар гэрийн болон сэтгэл санааны асуудал байвал өөрийн шүүд удирдлагадаа мэдэгдэх;
- Ажлын ширээ, сандал, хувцасны шүүгээний бүрэн бүтэн байдал, цэвэрлэгээ, компьютер, цахилгаан хэрэгслүүдийн хэвийн ажиллагааг шалгаж, цахилгааны залгуурыг зориулалтын бусаар ашигласан, хэт ачаалал үүсгэсэн, залгуурыг дутуу залгасан, цахилгааны утас халсан эсэхийг өөрийн биеэр шалгаж, галын аюулгүй байдлыг хангана;
- Ажлын байранд ил гал гаргах /лаа, эрц, хүж асаах, тамхи татах г.м/, электрон тамхи татахыг хориглоно;
- Албан тасалгаанд хэт чанга дуу чимээ гаргах, бусадтай зүй бусаар харьцах, маргалдах, ноцолдох, барилдах, үлддэх албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр илүү цагаар ажиллах (өдөрт 4-өөс олон цагаар сунаж ажиллахыг хориглоно), шөнийн цагаар ажиллах зэргээр хөдөлмөрийн сахилга дэг журмыг зөрчихгүй байна;
- Үйлдвэр, лаборатори, агуулахын ажлын байранд хоол хүнс идэх, юм уухыг хатуу хориглоно, зөвхөн цайны өрөө, амралтын байранд цай уух, юм идэхийг зөвшөөрнө;
- Гар багаж, цахилгаан дрилл, тасдагч ашиглахын өмнө багажны үзлэгийг хийж, шаардлагатай зөвшөөрлийг авна;
- Халуун хэвийн тасдах зүлгэх ажиллагаа болон гагнуур, тусгаарлалтын ажил (ЛОТ), хязгаарлагдмал орчинд нэвтгэх. 1.5 метртээс дээш өндөрт ажиллах: 20м-гээс гол газар үзэх, газар шорооны ажил үийг бичиг баримт

Зураг 3-19. Ажлын байр тус бүрээр боловсруулсан аюулгүй ажиллагааны зааварчилгаа

Сика Монголиа ХХК нь Хөдөлмөрийн аюулгүй байдал болон Чанарын өдөрлөгийг жил бүрийн 9 дүгээр сард дотооддоо зохион байгуулдаг бөгөөд тус өдөрлөгөөр ажилчдын оролцоог нэмэгдүүлэх, санал бодлыг хүлээн авах, групп компанийн бодлого, соёлыг танилцуулах, түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг хийдэг. Энэ жилийн хувьд бүх ажилчид, ажил олгогч хамтран Аюулгүй ажиллагаа, Бүтээгдэхүүний чанарыг хангаж ажиллахаа амлаж, групп компаниас авсан ХАБЭА соёлын түвшинг тодорхойлох судалгааны үр дүнтэй танилцаж, байгууллагын сайн болон дутагдалтай асуудлууд дээр багаар ярилцаж, хариу арга хэмжээ төлөвлөсөн. Мөн нийт ажилчид 4 багт хуваагдан ажлын байрны үзлэг хийж, зөрчил, сайжруулалтыг санал болгосон. Хамгийн сүүлд байгууллагын Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, мэргэжлийн ангийн дүрмийн дагуу гамшиг ослын үед нүүлгэн шилжүүлэх ажиллагааг туршиж, дадлага сургуулилт хийж, үр дүнтэй өнгөрөөсөн. /Хавсралт-7. ХАБЭА болон Чанарын өдөрлөг, төсөвт үйл ажиллагааны зардал- 1,600,000 төгрөг/.



Зураг 3-20. ХАБЭА болон Чанарын өдөрлөг-2025



Зураг 3-21. ХАБЭА болон Чанарын өдөрлөг, Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний дагуу нүүлгэн шилжүүлэлтийн дадлага сургуулилт хийсэн байдал

Ажилчдын идэвхитэй амьдралын хэв маягт уриалах, эрүүл мэндийг дэмжих үүднээс 2025 оны 05 сард УБ хотод зохион байгуулагдсан “UB MARATHON-2025” бүх нийтийн марафон гүйлтийн дундын замд 5км 7 ажилтан, холын зай 21км-д 2 ажилтан, нийт 9 ажилтан хамрагдсан /Хавсралт-8. УБ Марафон бүртгэлийн баримт- 210,000 төгрөг/.



Зураг 3-22. УБ Марафон-2025 -д оролцсон байдал

Сика Монголиа ХХК-ийн техник үйлчилгээний хэлтэс нь бетоны 90кг туршилтын дээжийг гараар өргөдөг үйлдлийг тусгай зориулалтын цахилгаан өргүүр нэвтрүүлснээр лабораторийн техникчдийн хүнд ачаа өргөх, түүнтэй холбоотой гар хуруугаа хавчуулах зэрэг эрсдэлийг арилгаж чадсан.



Зураг 3-23. RDP бетоны сорьц өргөх, зөөх цахилгаан өргүүр ашиглаж эхэлсэн байдал

ЧНийт:	10,406,220.0 төгрөгийг сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажилд зарцуулсан байна.

3.3 Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хүснэгт 3-3 Орчны тохижилт, нөхөн сэргээх төлөвлөгөөний биелэлт


Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт

Сика Монголиа ХХК нь МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” хөтөлбөр болон Үндэсний мод тарих намрын өдрийг тохиолдуулан 2025 оны 10 сарын 11-нд Хан-Уул дүүргийн 14-р хороо, Айцын амны мод үржүүлгийн талбайд улиас, хайлаас, бор голт төрлийн 90ш мод суулгаж тарьсан /Хавсралт-9 Мод бургас, хөрс бордооны зардал- 600,000 төгрөг/.



Зураг 3-24. “Тэрбум мод” хөтөлбөр хүрээнд Үндэсний мод тарих өдөр мод тарьсан байдал

Гадна талбайд явган хүний явах хэсгийг тусгаарлан шугам татаж будсан, мөн ачаа ачих тавцан, галын сарай зэргийн өнгө будгийг сэргээн дахин шинээ будах ажлыг зохион байгуулсан.



Зураг 3-25. Гадна талбайн будгийн ажил хийж буй байдал

Агуулахын гадна талбайн зэрлэг өвс, шарил зэргийг тайруулж, тасдуулан орчны харагдах байдал болон шар өвсний галын аюулгүй байдлаас урьдчилан сэргийлж ажилласан. /Хавсралт-10. Шар өвс, зэрлэг ургамал хадуулсан зардал- 600,000 төгрөг/.



Зураг 3-26. Шар өвс, зэрлэг ургамлыг тайруулсан байдал

Нийт:	1,200,000.0 төгрөгийг орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөт ажилд зарцуулсан байна.
--------------	--

3.4 Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө


Хүснэгт 3-4 Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний биелэлт

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв
“Сика Монголиа” ХХК-ийн Бетоны нэмэлтийн үйлдвэр, агуулах төслийн бүс нь төв суурины бүс, хүн амын суурьшилт бий болоод удаж байгаа ба энэ хугацаанд ямарваа нэгэн түүх, соёлын дурсгалт зүйлс, эртний олдворууд олдсон тохиолдол байхгүй тул энэ талаар мөн тусгаагүй.	

3.5 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 3-5 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Биелэлт
---	--	---------

1 Ашиглалтын шаардлага хангахгүй болон дадлага сургуулилтад ашигласан 4кг-ийн ABC төрлийн галын хор 10ш, сэрээт өргөгч дээр 2кг галын хор 5ш, сүлжээ серверийн өрөөнд CO2 төрлийн нүүрсхүчлийн хийн галын хор 3ш шинээр худалдан авч ажлын байранд байршуулсан.	 Зураг 3-27. Нүүрсхүчлийн галын хор, сэрээт өргөгчид галын хол байрлуулсан байдал /Хавсралт-11. Галын хор худалдан авсан баримт- 1,556,500 төгрөг/.
2 Галын багаж хэрэгсэл авч ашиглахад бэлэн байдлаар байрлуулах (амьсгалын нэг бүрийн хамгаалалтын аппарат, галын шүүгээ, каск, гар чийдэн, бусад иж бүрдэл гэх мэт), галын унтраах хэрэгслийн бэлэн байдал, ажиллагааг шалгах	 Зураг 3-28. Ажилчдад өвөл зуны ажлын хувцас тавьсан байдал Сика Монголиа ХХК-ийн томилогдсон галын идэвхтэн гишүүд нь ажлын байранд байршуулсан галын хор, сарайн иж бүрдэл, хэрэгслийн бүрэн бүтэн, найдвартай ажиллагааг шалгадаг ба улирал тутам галын дохиоллын системийн гэрээт компаниар үзлэг шалгалт, тестийг хийлгэдэг /Хавсралт-12. Галын хор, гал унтраах системийн үзлэг шалгалтын тайлан хуулбар/.



Зураг 3-29. Галын идэвхтэн гишүүдэд галын дохиоллын сургалт авсан байдал



Зураг 3-30. Галын дохиолол, утаа мэдрэг, таазны шугаман мэдрэгчийн ажиллагааг шалгаж буй байдал.

Өдөр тутам байнга ашиглагддаг түүхий эд, бэлэн бүтээгдэхүүний Хор Аюулын Лавлах Мэдээллийг нэгтгэн, матриц болгон нийт ажилчдад дотоод сургалтаар танилцуулж, ажлын байранд байршуулсан.

Document	Material Safety Data sheet	Version	Version
Issued	01/01/2024	01/01/2024	01/01/2024
Approved	General Manager	Date	12/ / 2024
Approved	General Manager	Date	12/ / 2024



ХИМИЙН БОДИСЫН ХОР АЮУЛЫН ЛАВЛАХ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН ХҮСНЭГТ
/ Sika Mongolia MSDS Matrix /


2024.12.30

														2024.12.3
№	Олон улсын нэршил International name	CAS дугаар CAS number	Төлөв Appearance	pH	NFPA Зарчлал NFPA Hazard			Гал авалцах хэм Flash point, °C	Тэсрэх доод, дахаа агуулга LEL/ UEL, V%	Аюулын тэмдэг, дохио үг GHS-Hazard Pictograms or Signal Word	Аюулын Н- код Hazard code H-code	Хорьу чанарын мэдээлэл /Хөвдөр, мутаци, нэгэн урсгалыг, ухуулын тулзэрэл/ Toxicity (carcinogenic, mutagenic, or reproductive and LD50)	ХАЛМ шинэчлсэн огноо MSDS revised year	
					Эрүүл мэнд Health hazard	Галын малалт Flammability hazard	Уусгай тэмдэг Environmental hazard							
1	Sika Signu! / MasterRoc (SA193, SA167, 5667 AFL)	-	Шингэн	2-3	2	0	0	COR to metals	NA	NA	 	H290 H316 H318	Toxity to aquatic Усвч орчинд хортой	2024.10.14
2	Sika ViscoCrete / MasterCement (SKY5588)	-	Шингэн	5-8	1	0	0	-	>100	NA	Warning	H316 H318	NA	2024.09.25
3	Sika ViscoCrete (5500; 5510; 5520; 5540; 5560)	-	Шингэн	4-6	1	0	0	-	NA	NA		H316	NA	2024.12.27
4	Sika ViscoCrete 5520W	-	Шингэн	3-6	2	0	0	OXY	NA	NA	 	H272 H316 H319	LD50 oral (rat) 1600 mg/kg	2024.12.27

Бодис урвалжуудын
хор аюулын зэргийг
харуулсан матриц,
самбарыг ажлын
байранд байршуулах

		ХИМИЙН БОДИСЫН NFPA ЗЭРЭГЛЭЛ, GHS ТЭМДЭГ, Н-КОД CHEMICAL NFPA CLASSIFICATION CODES, GHS HAZARD PICTOGRAMS AND H-CODES  Зураг 3-31. ХАЛМ матриц нэгтгэсэн байдал. /Хавсралт 13. Химийн бодисын ХАЛМ матриц, мэдээллийн самбар, постер хэвлүүлсэн баримт – 3,441,900 төгрөг/.
4	Хөдөлмөрийн аюулгүй байдлын үйл ажиллагаа, ХАБЭА сургалт болон Химийн бодисын хадгалалт, аюулгүй байдлын талаар сургалт зохион байгуулж байх	Сика Монголиа ХХК нь 2025 онд аюулгүй ажиллагааг сайжруулах, ажилчдын аюулгүй ажиллагааны зан төлөв, мэдлэг мэдээллийг сайжруулах тал дээр дараах үзүүлэлттэй ажилласан байна.  Зураг 3-32. Сика Монголиа ХХК-ийн ХАБЭА тоон үзүүлэлт Сика групп компаниас барьж байгаа Тогтвортой хөгжил, Хөдөлмөрийн аюулгүй байдлын бодлогын хүрээнд бид 2028 он гэхэд нас барсан осол гэмтлийг “0” буюу ZERO болгох, хугацаа алдсан хүнд төрлийн осол гэмтлийн хэмжээг <2 LTI /1000FTE (<i>Lost Time Accident</i>), Хөнгөн бэртэл, гэмтлийн тоо хэмжээг бууруулж <2 LTI /1000FTE (<i>Total recordable injury</i>) түвшинд хүргэх зорилт тавин

ажиллаж байна. Үүний хүрээнд ажлын байрны сөрөг нөлөөллийг бууруулах, ажилчдыг сургах, чадавхижуулах ажлуудыг үе шаттай хэрэгжүүлж байна.



Зураг 3-33. Сика групп компанийн Тогтвортой хөгжлийн зорилт-2028

Компани нь 2025 онд ХАБЭА-тай холбоотой 6ш дотоод журам, үйлдвэр агуулахын 5ш стандарт ажлын заавар (SWP), 4ш ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгааг шинэчлэн боловсруулж, өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөн хэрэгжүүлж байна.

- EHS-Pr-002 - Эрсдэлийн үнэлгээний журам.v3.20250416.pdf
- EHS-Pr-004 - Өндөр хэмийн ажлын журам.v3.20250416.pdf
- EHS-Pr-005 - Хязгаарлагдмал орчинд ажиллах журам.v3.20250416.pdf
- EHS-Pr-006 - Өндөрт ажиллах журам.v3.20250416.pdf
- EHS-Pr-007 - Цоожлох, пайзлах журам.v3.20250416.pdf
- EHS-Pr-008 - Сэрээт өргөгчийн аюулгүй ажиллагааны журам.v2.20251003.pdf
- Тээврийн шаардлага - Батлагдсан.20250801.pdf

Зураг 3-34. Шинэчлэн боловсруулсан байгууллагын дотоод журмууд


Мөн ХАБЭА тухай хууль, 2025 оны Сургалтын төлөвлөгөөний дагуу заавал хамрагдах Нийт ажилтны сургалт, Ажил олгогч болон Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх комиссыг чадавхижуулах аюулгүй ажиллагааны сургалтууд, эрсдэлтэй ажлын сургалт болон групп компанийн төлөвлөгөөт сургалт, арга хэмжээг зохион байгуулсан байна. Тухайлбал,

- 03.07 -нд ЛОТО буюу Энергийн тусгаарлалт
- 03.14, 03.15-нд Өндөрт ажиллах болон Өндөр хэмийн ажил гүйцэтгэх сургалт
- 03.21-нд Хязгаарлагдмал орчинд ажиллах
- 03.26 – Гал түймэр унтраах практик дадлага сургуулилт
- 05.09-нд Нийт ажилтны ХАБЭА сургалт


- 05.20-нд Ажил олгогч Удирдах ажилтны ХАБЭА сургалт, ҮОСБ комиссын сургалт
- 10.29-нд Химийн бодисын аюулгүй ажиллагааны сургалт /Хавсралт 14. ХАБЭА гаднаас авсан сургалтын тайлан болон зардал – 10,986,523.0 төгрөг/.



Зураг 3-35. Тусгаарлалт хийх үеийн ХАБЭА сургалт



Зураг 3-36. Хязгаарлагдмал орчинд ажиллах сургалт




Зураг 3-37. Өндөрт ажиллах, өндөрийн бүс хэрэгслийн сургалт




Зураг 3-38. Нийт ажилтны болон Ажил олгогчийн сургалт

2025 оны 01 дүгээр сарын 10-нд “MSDS matrix, химийн бодисын хор аюул, холимог хадгалалт” сэдэвт дотоод сургалтыг зохион байгуулж нийт ажилчдад химийн бодисын ХАЛМ-ыг танилцуулж, агуулахын холимог хадгалалтын дүрмийг танилцуулсан.



Зураг 3-39. Химийн бодисын ХАЛМ танилцуулах дотоод сургалт

2025 оны 10 дүгээр сарын 29-нд “Химийн бодисын аюулгүй ажиллагаа” сэдэвт сургалтыг гэрээт байгууллагатай хамтран зохион байгуулсан. Тус сургалтанд нийт 16 ажилтан хамрагдсан.



Зураг 3-40. Химийн бодисын аюулгүй ажиллагааны сургалтын үеийн зураг

2025 онд Сика Монголиа ХХК нь ажилчдын мэдлэг мэдээллийг сайжруулах, дүрэм журмыг танилцуулах, аюулгүй ажиллагаанд чадавхижуулах үүднээс ХАБЭА-тай холбогдолтой нийт 810 цагийн танхимын сургалтыг зохион

		байгуулсан ба нэг хүнд оногдох сургалтын хүн цаг ойролцоогоор 27.0 цаг (академик) байна.
5	Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар ажилчдад танин мэдүүлэх талаар сургалт, зохион байгуулах	ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ ДАДЛАГА СУРГУУЛИЛТЫН ЯВЦЫН ЗУРАГ 2025 оны 03 сарын 27 Гамшгаас хамгаалах, гал түймрий үед ажиллах шүүргэ дадлага сургуулилыг ХУД-ын ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВРАХ 14-р ангитай хамтран зохион байгууллаа. Тус сургалтанд үйлдвэрийн байршилд 15 ажилтан хамрагдав.  Нэгтгэсэн: ХАБЗА Н.Доржготов Зураг 3-41. Гал түймэр унтраах, практик дадлага сургуулилт зохион байгуулсан байдал /Хавсралт 15. Галын практик сургалтын тайлан/.
6	Химийн бодисын асгаралтаас хамгаалах, асгаралтын үед авах арга хэмжээний практик сургалт зохион байгуулах	Химийн бодисын асгаралтаас хамгаалах, тавиурын системийг механик гэмтлээс үүднээс түүхий эдийн агуулахын тавиурын системийн хуучин байсан хамгаалалтын төмөр багануудыг шинэчлэн, сайжруулсан.



Зураг 3-42. Агуулахын тавиурын хатуу хамгаалалтыг шинэчилсэн байдал

2025 оны 05 сарын 22-нд Химийн ослоос хамгаалах төлөвлөгөөний дагуу “Химийн бодисын асгаралтын үед ажиллах дадлага сургуулилт”-ыг дотооддоо зохион байгууллаа. Дадлага сургуулилтын хүрээнд аврах ажиллагааны бүлгэм, Эмнэлгийн анхны тусламжийн бүлгэм, Хэв журам харуул хамгаалалтын бүлгэмд хуваагдан 1.0тн-ийн сав бүхий шингэн бодис сэрээт өргөгчөөр зөөх үед асгаралт тохиолдвол хэрхэн хариу арга хэмжээ авах талаар сургуулилт хийлээ. Тус сургалтанд үйлдвэр, агуулах, лабораторийн ажилчид, удирдлагууд нийлсэн 13 ажилтан хамрагдав /Хавсралт 16. Химийн бодисын асгаралтын практик сургалтын тайлан/.



Зураг 3-43. Химийн бодисын ослоос хамгаалах төлөвлөгөө, асгаралтын үед ажиллах практик сургалт зохион байгуулсан

7	Химийн бодисын агуулахын стандарт шаардлагыг хангах, агуулахын дүгнэлт авах, болзошгүй тохиолдлоор химийн бодис асгарсан тохиолдолд хэрэглэх зориулалтын хувцас хэрэгсэл, иж бүрдэл, хэрэглэгдэхүүн шинэчлэх, бэлтгэх байлгах	Сика Монголиа ХХК нь Сонсголон агуулах нь “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458:2014” стандартын шаардлагыг хангасан тул Нийслэлийн Байгаль Орчны газраас БО-ны улсын байцаагч газар дээр нь хянан шалгаж, ажиллан “Химийн бодисын агуулахын дүгнэлт”-ийг 2025 оны 10 сарын 07-нд олгосон /Хавсралт 17. Химийн бодисын агуулахын дүгнэлт/.  СИКА МОНГОЛИА ХХК-Д НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧИ АГЕНТЛАГ БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ Нийслэлийн Засаг захиргааны III байр, Ж.Самбуугийн гудамж, 4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160 0011 Утас: (976-11) 32 37 80, Факс: (976-11) 31 80 03 Цахим шуудан: admin@environment.ub.gov.mn Цахим хуудас: www.environment.ub.gov.mn 2025.10.07 № 01/13-01/496-20 Химийн бодисын агуулахын тухай Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 01/04 дугаартай “Химийн хорт болон аюултай бодис ашиглах, хадгалах, дахин боловсруулах үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Сика Монголиа ХХК-ийн үйл ажиллагаанд Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Хог хаягдлын тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, норм, стандартын хэрэгжилтийн байдалд Байгаль орчны хяналтын улсын байцаагч Ж.Батхүү 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдөр Хөдөлмөрийн аюулгүй байдлын инженер Н.Доржготовыг байлцуулан хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ. Сика Монголиа ХХК-ийн химийн бодис хадгалах агуулах нь “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага MNS 6458:2014 стандартын шаардлагыг хангаж байна. Энэхүү дүгнэлт нь тухайн химийн бодисын хадгалах агуулахад хамаарна. (Агуулахын зориулалт, орц, гарц, байршил, хадгалах химийн бодис, хариуцагч этгээд өөрчлөгдсөн өдрөөс дүгнэлт дуусгавар болно.) Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн дагуу шалгалтын явцад хууль тогтоомж зөрчигдсөн, гаргасан шийдвэр үндэслэлгүй гэж үзэн улсын байцаагчийн дүгнэлтийг эс зөвшөөрсөн тохиолдолд гомдлоо шалгалт хийсэн байгууллагын дээд албан тушаалтанд гаргах эрхтэй. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ Ж.БАТХҮҮ
---	---	--

Зураг 3-44. Химийн бодисын агуулахын дүгнэлт – Сонсголон агуулах

		Химийн бодисын ослоос хамгаалах төлөвлөгөөг боловсруулан Нийслэлийн ОБЕГ-ийн Гамшгийн Шуурхай Удирдлагын Хэлтэсээр хянуулж батлуулсан.    ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ОСЛЫН ҮЕД АЖИЛЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ / БЕТОНЫ НЭМЭЛТИЙН ҮЙЛДВЭР, АГУУЛАХ - Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө 62 тоот / ХЯНАСАН: ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ХЭЛТСИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ, ДЭСЛЭГЧ НОБ-ЫН ГШУХ-ИЙН ХИМИ БИОЛОГИ, ЦАЦРАГ, ТЭССЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИСЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН, АХЛАХ ДЭСЛЭГЧ БОЛОВСРУУЛСАН: СИКА МОНГОЛИА ХХК-ИЙН БОХАБЗА АЖИЛТАН  Г.УРАНГОО О.ОДБАЯР Н.ДОРЖГОТОВ УЛААНБААТАР ХОТ 2025 ОН Зураг 3-45. Батлагдсан Химийн бодисын ослын үед ажиллах төлөвлөгөө Сика Монголиа ХХК нь болзошгүй гамшиг осол, химийн бодисын асгаралтын үед ашиглах тусгай хамгаалах хэрэгсэл (химийн бодист тэсвэртэй усны гутал, комбинзон, шүүлтүүртэй баг, урт бээлий, бүтэн нүүрний баг, нүдний гоогле шил)-ийг 4 хүний тоогоор бэлдэж, шинэчилсэн /Хавсралт 18. Химийн бодисын ослын үед ажиллах төлөвлөгөө болон иж бүрдэл шинэчилсэн баримт - 992,400 төгрөг/. <u>Химийн бодисын асгаралтын иж бүрдэл, хамгаалах хэрэгсэл:</u> Сика Монголиа ХХК-ийн хэмжээнд химийн бодисын асгаралтын үед ашиглах иж бүрдэлийг 8 байршилд, ослын шүршүүрийг 3 байршилд байрлуулсан бөгөөд анхын тусламж үзүүлэгч ажилчид улиарал бүр үзлэг шалгалт хийж, бүрэн бүтэн байдлыг хангаж, хариуцан ажилладаг. 1000л багтаамж бүхий асгаралт тосох bund 2ш байна.   Зураг 3-46. Химийн бодисын асгаралтын иж бүрдэл, тусгай хамгаалах хэрэгслийн бэлэн байдлын жагсаалт
8	Цахилгааны техник ашиглалтын дүрмийн дагуу газардуулах байгууламжийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	2025 оны 10 сард цахилгааны тусгай зөвшөөрөлтэй гэрээ компаниар агуулахын газардуулгын байгууламжийг хийлгэж, хэмжилт протоколыг хийлгэсэн /Хавсралт 19. Газардуулгын проткол болон, хийлгэсэн гэрээний ажлын дүн – 8,393,000 төгрөг/.

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Сика Монголиа” ХХК-ийн БЕТОН ЗУУРМАГИЙН НЭМЭЛТ БОДИС ИМПОРТЛОХ, АШИГЛАХ, ХАДГАЛАХ АГУУЛАХ төслийн 2025 оны БОМТ – БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

		“SIKA” агуулахад газардуулга хийсэн фото акт																					
OPTOMASTER LLC “ОПТОМАСТЕР” ХХК Газардуулгын байгууламж хийх үеийн фото тайлан		Огноо/Date: 2025.10.20																					
DOOSAN 900-60-3R3 SS Ажлын нэр: Газардуулгын байгууламжийн газар шорооны ажлын зураг.																							
Хэмжилт хийсэн багаж: UNI-T UT521 <table><tr><th rowspan="2">д/д</th><th rowspan="2">Байгууламжийн нэр</th><th rowspan="2">Газардуулсан тоноглол, байгууламжийн нэр</th><th colspan="2">Газардуулгын эсэргүүцэл, Ом</th><th rowspan="2">Дүн</th></tr><tr><th>Боломжит утга</th><th>Хэмжилтийн утга</th></tr><tr><td>1</td><td>Сика ХХК-ын Сонсголон дахь агуулах.</td><td>Барааны агуулахын карказ, 0,4кВ-ын цахилгааны самбар</td><td>4</td><td>1,99 Ом</td><td>Тэнцэнэ.</td></tr><tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr></table>				д/д	Байгууламжийн нэр	Газардуулсан тоноглол, байгууламжийн нэр	Газардуулгын эсэргүүцэл, Ом		Дүн	Боломжит утга	Хэмжилтийн утга	1	Сика ХХК-ын Сонсголон дахь агуулах.	Барааны агуулахын карказ, 0,4кВ-ын цахилгааны самбар	4	1,99 Ом	Тэнцэнэ.						
д/д	Байгууламжийн нэр	Газардуулсан тоноглол, байгууламжийн нэр	Газардуулгын эсэргүүцэл, Ом				Дүн																
